



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2023 оны 04 сарын 04 өдөр

Дугаар 5/42

Хэрлэн сум

**Албан хаагчдад буцалтгүй
тусламж олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, аймгийн Засаг даргын Тамгын газрын “Дотоод журам”-ын 7 дугаар зүйлийн 7.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Э.Мөнх-Эрдэнэ, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн С.Оюун-Эрдэнэ, Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн Ж.Цэнджав нарын гаргасан өргөдлийн дагуу нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор тус бүр 300,000 (гурван зуун мянга) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламжид шаардагдах 900,000 (есөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын тэтгэмж, урамшууллын зардлаас санхүүжүүлэхийг Нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод ажил, агентлаг хариуцсан мэргэжилтэн (Ш.Эрдэнэжаргал)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР